

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2019 оны 8 сарын дугаар

Тэргүүн мэдээ.

“Япон фестиваль 2019” арга хэмжээнд оролцов.



2019 он 8-р сарын 17, 18-ны өдөр зохион байгуулагдсан “Япон фестиваль 2019” арга хэмжээнд ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар оролцов. Монголчуудад “Японыг бүхэлд нь” танилцуулах зорилгоор Японы соёл урлаг, аялал жуулчлалыг сурталчилсан энэхүү арга хэмжээнд Монголд бизнес эрхлэх сонирхолтой Японы ААН-үүд олноор оролцсон. ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд Япон бичгийн уран татлага зэрэг япон соёл урлаг сурталчлах үйл ажиллагаа явуулж, арга хэмжээнд оролцсон монголчуудад сонирхуулав. Эхний өдөр ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Тамура Эрико арга хэмжээний гол тайзан дээрээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сурталчилсан үг хэлж, ЦЕГ-тай хамтран зохиосон аюулгүй жолоодлогод уриалсан дууг танилцуулав.

Төслийн хэрэгжилт.

2019 оны хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутнуудын үдэлтийн арга хэмжээ болов.



8 сарын 16-ны өдөр Японы элчин сайдын ёслолын өргөөнд энэ оны “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрт” хамрагдсан оюутнуудын үдэлтийн арга хэмжээ болов. Энэ жил нийт 22 оюутан Японы их, дээд сургуульд мастер, докторын зэрэг олгох сургалтад хамрагдахаар явж байна. Үдэлтийн арга хэмжээ Элчин сайдын мэндчилгээгээр эхэлж, Сангийн дэд сайд, БСШУС-ын дэд сайд нар баяр хүргэн мэндчилгээ дэвшүүлэв. Оюутны төлөөлөл “Сайхан боломж олгосонд талархаж байна. Монголын ирээдүйг авч явах чадвартай боловсон хүчин болохын төлөө хичээнгүйлэн суралцах болно” хэмээн хариу талархал илэрхийлэв.

Дизель хөдөлгүүрт нийтийн автобусны тортог шүүгч төхөөрөмж (DPF) хүлээлгэн өгөв.



Гадаадад ЖДҮ-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжих төслийн хүрээнд хэрэгжиж буй “Улаанбаатар хотын нийтийн тээврийн автобусны дизель хөдөлгүүрт DPF (Diesel Particulate Filter) тортог шүүгчийг суурилуулж хөдөлгүүрээс ялгарах тортогжилтыг бууруулах туршилтын төсөл” 2019 оны 9 сард хэрэгжиж дуусч байгаатай холбогдуулан 8 сарын 1-ний өдөр тортог шүүгч төхөөрөмж хүлээлгэн өгөх ёслол болов. Улаанбаатар хотын нийтийн тээврийн 24 автобусанд суурилуулж туршсан Сайтама хотын Комотек компанийн тогтог шүүгч DPF төхөөрөмж нь тортогийн хэмжээг 97 % бууруулж байгаа нь тогтоогдсон байна. Цаашид DPF төхөөрөмжийн ашиглалт,

засвар үйлчилгээ хэвийн явагдаж, Улаанбаатарын агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

ЖАЙКА-ийн Төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагаагаар дамжуулан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд төрөлтийг аюулгүй болгоход чиглэсэн төсөл хэрэгжиж эхлэв.



2019 оны 8 сарын 7-ны өдөр "Ургийн хяналтын монитормыг эх барихын практикт нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлснээр перинаталь үеийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах төсөл"-ийн (Хэрэгжүүлэгч байгууллага нь японы Тооцу ХК) үйл ажиллагааг эхлүүлэх ёслолын арга хэмжээ болж Эрүүл мэндийн сайд Сарангэрэл оролцов. Энэхүү төслийн хүрээнд ЭХЭМҮТ болон Улаанбаатар хотын 1,2,3-р амаржих газарт тус бүр 6 ургийн хяналтын монитор болон 1 эрчимтэй хяналтын систем хүлээлгэн өгч байгаа бөгөөд улмаар аюулгүй төрөлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үр нөлөөг туршин харуулж, ургийн хяналтын монитормын оношилгооны удирдамж, зааврыг боловсруулах юм. Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл тоног төхөөрөмжөөс гадна хүний нөөцийг чадавхжуулах нь чухал ач холбогдолтой болохыг тэмдэглээд энэхүү төсөлд ихээхэн найдлага тавьж байгаагаа илэрхийлэв.

ЖАЙКА-ийн Сайн дурын (JV) үйл ажиллагаа

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга (Гоо сайханч сайн дурын гишүүний үйл ажиллагаа)



ЖАЙКА нь "Аж үйлдвэрийг төрөлжүүлэх, бүс нутгийн хөгжлийн стратегийг бэхжүүлэх" гэсэн тус улсын хөгжлийн зорилтыг биелүүлэхэд хувь нэмэр болох үүднээс Төв аймгийн МСҮТ-ийн үсчин сайханчийн ангид гоо сайханч мэргэжилтэй сайн дурын гишүүн илгээн ажиллуулж байна. Сома Мадока сайн дурын гишүүн нь 2017 оны 2 сараас эхлэн 2 жилийн турш тус сургуулийн гоо сайхны багштай хамтран ажиллаж, оюутнуудад хичээл зааж иржээ. Тэрээр үйл ажиллагаагаа өндөрлүүлэн гоо сайхны сурах бичиг гаргасан байна. Энэхүү сурах бичиг нь Төв аймгийн МСҮТ-ийн гоо сайхны ангийн гарын авлага болон хэрэглэгдэхийн хамт номын сан ба гоо сайхны салонуудаар тараагдаж монголын гоо сайхны салбарын хөгжилд хувь нэмэр оруулах болов уу.

Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА) Монгол дахь төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс
(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 / E-mail: mg_oso_rep@jica.go.jp

Web: www.jica.go.jp/mongolia/index.html / FB: [JICA Mongolia](https://www.facebook.com/JICA.Mongolia)